



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 60

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжийн дагуу “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн хөрөнгө оруулалтаар Шинэжинст сумын ЗДТГ-т худалдан авсан Land Cruiser 200 маркын автомашин нь Улаанбаатар хотын харьяат иргэн Ц.Батдоржийн нэр дээр, Богд сумын ЗДТГ-т худалдан авсан Land Cruiser 100 маркын автомашин нь Баянхонгор аймгийн харьяат “Баянхонгор төмөрт” ХХК-ийн нэр дээр, Эрдэнэцогт сумын ЗДТГ-т худалдан авсан Land Cruiser 200 маркын автомашин нь Улаанбаатар хотын харьяат иргэн Э.Баярмагнайн нэр дээр эзэмшилтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4 дугаар зүйлийн 4.1.1 дэх “Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй”, 4.1.7 дахь “Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдалд албан шаардлага өгнө” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Суудлын автомашины эзэмшигчийг төсвийн байгууллагын нэр дээр шилжүүлж зөрчлийг арилгах.

2518079

2. Албан шаардлагын биелэлтийг 2018.06.10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн ОНӨГ-ын дарга Ц.Идэрмөнх, ахлах мэргэжилтэн Л.Доржханд нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Б.ДОЛЖМАА

Б.АЗБАЯР

ЗӨВШӨӨРСӨН:

АЙМГИЙН ОНӨГ-ЫН

ДАРГА

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Ц.ИДЭРМӨНХ

Л.ДОРЖХАНД

¹. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 61

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжийн дагуу “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн сайдын 2017.11.20-ний өдрийн А/452 тоот тушаалаар 5 суманд 6 ширхэг мотоциклийн үнэнд 10,8 сая төгрөг батлагдаж, аймгийн ЭМГ-ын даргад эрх шилжүүлсний дагуу аймгийн ОНӨГ-аас зарласан тендэрт “Хос соронз” ХХК шалгарч 10,6 сая төгрөгөөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулжээ.

Баацагаан суманд 2 ширхэг, Заг, Жинст, Богд, Жаргалант сумдад тус бүр 1 ширхэг, нийт 6 ширхэг мотоциклийн эзэмшигчийн аудитаар шалгахад тухайн хөрөнгийг хүлээлцсэн акт байхгүй, хөрөнгийг эзэмшигчийн гэрчилгээг гаргуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4 дугаар зүйлийн 4.1.1 дэх “Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй”, 4.1.7 дахь “Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нэхцөл байдалд албан шаардлага өгнө” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**


2518081

1. Мотоциклийн гэрчилгээг гаргуулж, эзэмшигчийг төсвийн байгууллагын нэр дээр шилжүүлж зөрчлийг арилгах

2. Албан шаардлагын биелэлтийг 2018.06.10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Эрүүл мэндийн газрын дарга А.Ганболд, нягтлан бодогч П.Оюунтунгалаг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ


АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Б.ДОЛЖМАА
Б.АЗБАЯР

АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН

ДАРГА
НЯГТЛАН БОДОГЧ



А.ГАНБОЛД
П.ОЮУНТУНГАЛАГ

¹. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 62

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжийн дагуу “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Политехникийн коллежийн төгсөгчдийг ажлын байраар хангах, бичил нийтийн аж ахуйн үйлчилгээний төвийн 146.97 м2 талбай бүхий сэндвичин барилгыг барих арга хэмжээнд улсын төсвөөс 50,0 сая төгрөг батлагдаж, тухайн барилгыг хүлээн авч ашиглаж байна.

Аудитаар хөрөнгийн бүртгэлийг “улган шалгахад барилгыг санхүүгийн тайланд 30,4 сая төгрөгөөр бүртгэж, 2017 онд санхүүжүүлсэн дүнгээр буюу 19,6 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4 дугаар зүйлийн 4.1.1 дэх “Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай

2518083


хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй", 4.1.7 дахь "Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нэхцөл байдалд албан шаардлага өгнө" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр баригдсан барилгын үнийг санхүүгийн тайланд залруулж бүртгэх

2. Албан шаардлагын биелэлтийг 2018.06.10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Политехникийн коллежийн захирал Д.Бат-Орших, нягтлан бодогч Ц.Цэвээнсүрэн нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Б.ДОЛЖМАА
Б.АЗБАЯР

АЙМГИЙН ПОЛИТЕХНИКИЙН КОЛЛЕЖИЙН

ЗАХИРАЛ
НЯГТЛАН БОДОГЧ



Д.БАТ-ОРШИХ
Ц.ЦЭВЭЭНСҮРЭН

¹. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.